



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 01 сарын 21 өдөр

Дугаар Б/82

Улаанбаатар хот

**Т.Чимэгтэйд сахилгын
шийтгэл ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 37.1.12, 48 дугаар зүйлийн 48.1.2, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.3, 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 3.4.3, 5.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”ын 10.1, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартын 5.6.5, 5.6.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Тэrsайханы Чимэгтэй нь хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандаж, Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг зөрчсөн нь иргэний мэдээлэл, түүний гаргасан тайлбараар тогтоогдож байх тул түүнд албан тушаалын цалингийн хэмжээг 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 6 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Т.Чимэгтэйд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвэл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

571000227